

“ТӨРИЙН ОРОН СУУЦНЫ КОРПОРАЦИ” ТӨХХК-ИЙН  
2024 ОНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШИН,  
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛ

2025.01.10

“Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 13 тоот тогтоолоор Компанийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарыг үндсэн 39 ажилтан, гэрээт 53 ажилтантайгаар баталж, 5 газар, 1 төслийн нэгжтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 12 сарын 21-ний өдрийн 701 дугаар тогтоолоор “Төрийн Орон Сууцны Корпораци” ТӨХХК-ийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсныг 2024 оны 11 сарын 07-ны өдрийн 548 дугаар тогтоолоор тодотгон баталсан. Тайлант онд нийт орлогыг 15.8 тэрбум төгрөгөөр, нийт зардлыг 17.1 тэрбум төгрөгөөр, 1.2 тэрбум төгрөгийн алдагдалтай, үүнээс хөрөнгө оруулалтад нийт 15 нэр төрлийн 89 ширхэг 171.8 сая төгрөгийг төлөвлөсөн.

“Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК нь гүйцэтгэлээр хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрийн бүтээн байгуулалтын үр дүнд бий болсон бүтээгдэхүүн үйлчилгээний борлуулалт, түрээсийн үйл ажиллагаанаас нийт 13.3 тэрбум төгрөгийн орлого олж 15.3 тэрбум төгрөгийн зардал гарган 2.0 тэрбум төгрөгийн алдагдал хүлээгээд байна. Тайлант оны үйл ажиллагааны зардал 5.7 тэрбум төгрөг төлөвлөснөөс нийт 5.2 тэрбум төгрөгийг зарцуулж ажилласан.

ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛ

Нийт 15.8 тэрбум төгрөгийн орлого бүрдүүлэхээр төлөвлөснөөс гүйцэтгэлээр нийт 13.3 тэрбум төгрөгийн орлого төвлөрсөн. Үүнээс үндсэн үйл ажиллагааны орлого 56 хувь, бусад орлого 44 хувийг эзэлж байгаа бөгөөд байгууллагын барьж ашиглалтанд оруулсан орон сууц борлуулснаас 837.4 сая төгрөг, орон сууц түрээсийн орлого 5.5 тэрбум төг, түрээсийн үйл ажиллагааны орлого 1.2 тэрбум төгрөг болон 492.6 сая төгрөгийн бусад орлогыг төвлөрүүлсэн.

| ОРЛОГО                                                                                   | Х.Нэгж  | 2024 он      |              | биелэлт тоогоор | биелэлт хувиар |
|------------------------------------------------------------------------------------------|---------|--------------|--------------|-----------------|----------------|
|                                                                                          |         | Төлөвлөгөө   | Гүйцэтгэл    |                 |                |
|                                                                                          | мян.төг | 15,849,497.6 | 13,307,272.6 | (2,542,225.0)   | 83.96          |
| Борлуулалтын орлого                                                                      | мян.төг | 862,788.2    | 837,365.2    | (25,423.0)      | 97.05          |
| Солонго 1.2 төслийн техник хяналтын орлого                                               | мян.төг | 2,676,417.4  | -            | (2,676,417.4)   | -              |
| Солонго 1.2 төслийн улсын төсвөөр хийгдэж буй хөрөнгө оруулалтын техник хяналтын орлого  | мян.төг | -            | 158,166.3    | 158,166.3       | -              |
| Түрээсийн орлого /1,512 айл/                                                             | мян.төг | 5,314,109.9  | 5,539,426.7  | 225,316.8       | 104.24         |
| Түрээсийн санд шилжсэн орон сууцны төсвөөс авах төлбөр /ЗГ-ийн 2016 оны 38, 169 тогтоол/ | мян.төг | 5,000,000.0  | 5,000,000.0  | -               | 100.00         |
| Хөрөнгө оруулалт, хамтын ажиллагааны гэрээний төлбөрийн орлого                           | мян.төг | 1,000,000.0  | 40,000.0     | (960,000.0)     | 4.00           |
| Түрээслээд өмчлөх үйл ажиллагааны орлого                                                 | мян.төг | 796,182.1    | 1,239,710.1  | 443,528.0       | 155.71         |
| Бусад орлого                                                                             | мян.төг | 200,000.0    | 492,604.3    | 292,604.3       | 246.30         |

1. Буянт-Ухаа-1, 2 төсөл, Аймаг бүрт 1000 айлын орон сууц төсөл, 40,000 айлын орон сууц хөтөлбөрүүдийн хүрээнд баригдсан орон сууц, гараж, зоорийн давхрын үлдэгдлийг 2020-2024 онуудад бүрэн барагдуулах: Уг төлөвлөгөөний хүрээнд 2024 онд 862.7 сая төгрөг

төвлөрүүлэхээс 837.4 сая төгрөгийн борлуулалтын орлогыг 270 иргэнээс төвлөрүүлээд байна.

2. ТОСК нь 2011-2015 онуудад орон сууцны барилга болон гадна инженерийн шугам, сүлжээ, цэвэрлэх байгууламжийн бүтээн байгуулалтанд зориулж хувийн хэвшлүүдтэй “Хөрөнгө оруулалт, хамтын ажиллагааны гэрээ” байгуулж барилгын санхүүжилтийг хийсэн. Гэрээний дагуу санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын эргэн төлөлт хугацаандаа хийгдээгүйгээс үүссэн авлагын үлдэгдэл 17.2 тэрбум төгрөгт хүрээд байгаа бөгөөд эдгээр авлагуудаас 2024 онд ХОХАГ-тэй хууль, хяналтын байгууллагаар шийдвэрлэгдэж байгаа 1 байгууллагаас 1.0 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс Хэнтий аймгийн ЗДТГазар, Бүрд констракшн ХХК-аас 40.0 сая төгрөгийн авлага төлөгдсөн. “Могул скай” ХХК-аас нийт 164,43 м.кв-183,88 м.кв талбай бүхий 9 ширхэг орон сууцыг шилжүүлэн өгөхөөр гэрээ байгуулсан боловч уг орон сууцыг улсын комисс хүлээн аваагүй учраас үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ гарах боломжгүй. Үүнээс шалтгаалан аль нэг этгээдийн өмчлөлд шилжих боломжгүй байна. Иймд эдгээр эрхийн доголдолыг арилгахаар ажиллаж байгаа тул төлөвлөгөө биелэгдээгүй.
3. Нийт 1,511 орон сууцны 6.09 /үйл ажиллагааны шимтгэлтэй дүн/ тэрбум төгрөгийн түрээсийн орлого төвлөрүүлэхээс 6.7 тэрбум төгрөгийг төвлөрүүлэн ажилласан. Үүнд, 592 иргэний 1.7 тэрбум төгрөгийн энгийн түрээсийн орлого, 919 иргэний 5.0 төгрөгийн /үүнээс 1.2 тэрбум төгрөг нь түрээслээд өмчлөхийн 25% шимтгэл/ түрээслээд өмчлөх гэрээний 30% хувийн урьдчилгааны төлбөрийг төвлөрүүлж ажилласан.
4. Төрийн түрээсийн орон сууцны санд шилжүүлсэн орон сууцнаас 5.3 тэрбум төгрөгийн түрээсийн орлогыг төвлөрүүлнэ: 2024 онд 623 иргэний 1,7 тэрбум төгрөгийн энгийн түрээс, 888 иргэний 3.6 тэрбум төгрөгийн түрээслээд өмчлөхийн гэрээний эргэн төлөлт, нийт 5.3 тэрбум төгрөгийн түрээсийн орлого төвлөрүүлсэн. /25 хувийн шимтгэл суутгасан орлого/
5. Түрээслээд өмчлөх үйл ажиллагааны орлогыг 2024 онд 796.2 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 1.2 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлсэн. Учир нь 2024 онд нэмж 26 иргэнтэй нэмж түрээслээд өмчлөхийн гэрээ байгуулсанаар түрээслээд өмчлөх гэрээний орлого нэмэгдэж, уг орлогоос суутган авдаг 25 хувийн шимтгэлийн орлого нэмэгдсэн.
6. Төрийн түрээсийн орон сууцны санд шилжүүлсэн 1,289 айлын орон сууцны төлбөр 82,3 тэрбум төгрөгийг 2019 оноос улсын төсөвт суулгах замаар 5,0 тэрбум төгрөгийг авч Хөгжлийн банкнаас авсан зээлийн төлбөрийг төлсөн ба 2020-2024 онуудад шат дараатай улсын төсөвт суулгах замаар Түрээсийн орон сууцны санд шилжүүлсэн орон сууцны үнийг төвлөрүүлнэ: 2024 оны улсын төсөвт 5,0 тэрбум төгрөг суусан ба уг хөрөнгийг улсын төсвөөс шилжүүлэн авч Хөгжлийн банканд үнэт цаасны хүүгийн төлбөрийг төлсөн.
7. “Солонго 1,2” төсөл хэрэгжиж, барилга угсралтын ажил хийгдэж байгаатай холбоотойгоор төслийн 2024 онд хийгдэх ажлын техник хяналтын орлого болох 2.6 тэрбум төгрөгийг улсын төсөвт тусган авахаар төлөвлөсөн боловч тухайн ондоо ороогүй ба 2025 оны 2 дугаар сард СЯ-с шилжүүлсэн.

### **ЗАРДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛ**

Нийт 17.1 тэрбум төгрөгийн зардал төлөвлөснөөс зардлын гүйцэтгэл 15.3 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 3,25 тэрбум төгрөг буюу 11 хувиар тасалдсан. Үүнээс ерөнхий ба удирдлагын зардалд 34 хувь, санхүүгийн зардалд /үнэт цаасны хүүгийн зардал/ 56 хувь, бусад зардалд /борлуулсан бүтээгдэхүүний өртөг, үйл ажиллагааны бус зардал/ 33 хувийн зардал гаргасан.

Төлөвлөгөө тасалдсан шалтгаан нь “Солонго 1,2” төслийн техник хяналтын орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөсөн” Солонго 1,2” төслийн нэгжийн Ерөнхий ба удирдлагын зардал болох 2.6 тэрбум төгрөгийн санхүүжилт гараагүйтэй холбоотой.

| ЗАРДАЛ                                                                                          | Х.Нэгж  | 2024 он      |              | Зөрүү         | Хувь     |
|-------------------------------------------------------------------------------------------------|---------|--------------|--------------|---------------|----------|
|                                                                                                 |         | Төлөвлөгөө   | Гүйцэтгэл    |               |          |
|                                                                                                 | мян.төг | 17,144,287.1 | 15,350,023.7 | (1,794,263.4) | 89.53    |
| Ерөнхий ба удирдлагын зардал                                                                    | мян.төг | 5,766,172.0  | 5,256,392.6  | (509,779.4)   | 91.16    |
| Үйл ажиллагааны бус зардал                                                                      | мян.төг | 19,200.0     | 596,793.5    | 577,593.5     | 3,108.30 |
| Санхүүгийн зардал                                                                               | мян.төг | 7,992,267.1  | 8,650,232.8  | 657,965.7     | 108.23   |
| Борлуулсан бүтээгдэхүүний өртөг                                                                 | мян.төг | 690,230.6    | 846,604.8    | 156,374.2     | 122.66   |
| Солонго 1.2 төслийн нэгжийн Ерөнхий ба удирдлагын зардал /БХБСайдын 2021 оны 116 дугаар тушаал/ | мян.төг | 2,676,417.4  | -            | (2,676,417.4) | -        |

1. Ерөнхий ба удирдлагын зардал: 2024 онд 5.7 тэрбум төгрөгийн зардал төлөвлөснөөс 5.2 тэрбум төгрөг буюу 91 хувийн гүйцэтгэлтэй ажилласан. Цалингийн зардалд 1.69 тэрбум төгрөгийг төсөвлөснөөс гүйцэтгэлээр 1.69 тэрбум төгрөг буюу 3.8 сая төгрөгийн хэмнэлт хийсэн. Ерөнхий ба удирдлагын зардлын 32 хувийг цалингийн зардал бүрдүүлсэн.
2. Санхүүгийн зардал: 2024 онд санхүүгийн нөхцөл байдлаас хамааран Хөгжлийн банкинд үнэт цаасны хүүгийн төлбөрт 7.9 тэрбум төгрөгийг төлөхөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 8.6 тэрбум төгрөгийг хугацаанд нь төлсөн.
3. Борлуулсан бүтээгдэхүүний өртөг: 2024 онд 690.2 сая төгрөгийн зардал төлөвлөсөн боловч 846.6 сая төгрөгийн зардал гараад байна. Энэ нь 2024 онд борлуулалтад хүлээн зөвшөөрч бүртгэсэн борлуулсан бүтээгдэхүүн төлөвлөсөн хэмжээнээс илүү гарсантай холбоотой.
4. Үйл ажиллагааны бус зардал: 2024 онд 19.2 сая төгрөг төлөвлөснөөс 596.7 сая төгрөгийн зардал гараад байгаа нь СЯ-тай байгуулсан “Үүрэг гүйцэтгүүлэх гэрээ”-ний үлдэгдэл дүнд тооцогдсон алданги, компаний эзэмшлийн 4 автомашинд 2018 оноос хойш ногдсон торгууль зэрэг зардал гарсантай холбоотой.

### БОРЛУУЛАЛТЫН НЭГ ТӨГРӨГТ НОГДОХ ЗАРДАЛ

2024 оны зорилтот түвшинтэй харьцуулахад нийт орлогын төлөвлөгөө -20%, зардлын төлөвлөгөө -11% буюу орлогын бууралт нь зардлын бууралттай харьцуулахад 9 нэгжээр илүү буурсан байгаа нь орлогын нэг төгрөгт ногдох зардлын үзүүлэлтийг 1.15 төгрөгт хүрэхэд нөлөөлсөн.

### АВЛАГА

Тайлант хугацаанд нийт авлагын үлдэгдлийг 38.8 тэрбум төгрөгөөр бууруулж 70.6 тэрбум төгрөгт хүргэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 104.5 тэрбум төгрөгийн авлагатай байгаа бөгөөд 52.3 тэрбум төгрөгийн авлага буюу 50 хувийг түрээсийн орон сууцны сангийн төсвөөс авах авлага эзэлж байна. Мөн нийт авлагын 32 хувийг сум төсөл буюу хөдөлгөөнт тоног төхөөрөмжтэй холбоотой 33.8 тэрбум төгрөгийн авлага дангаараа эзэлж байна.

1. Түрээсийн орон сууцны авлагын үлдэгдэл: ЗГ-ын 2016 оны 38, 169-р тогтоолоор Түрээсийн орон сууцны санд шилжсэн 1,512 орон сууцны үнэ 57.3 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байгаагаас 2024 оны төсөвт 5,0 тэрбум төгрөгийг суутган авч үлдэгдэл авлага 52.3 тэрбум төгрөг болж буурахаар төлөвлөсөн ба гүйцэтгэлээр биелсэн.
2. Хөрөнгө оруулалт, хамтын ажиллагааны гэрээтэй байгууллагаас авах авлагын үлдэгдэл дүн: 2024 онд 1 байгууллагын 1.0 тэрбум төгрөгийг төлүүлж, үлдэгдэл авлагыг бууруулж 17.1 тэрбум төгрөгт хүргэхээр төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр нийт 40.0 сая төгрөг төлөгдөж энэхүү төлөвлөгөө биелэгдээгүй. /тайлбар нь дээрх орлого дээр/
3. Хөдөлгөөнт тоног төхөөрөмж авлага: Засгийн газрын 2022 оны 220 дугаар тогтоолоор Хөдөлгөөнт тоног төхөөрөмжийн авлагыг Батлан хамгаалахын яаманд шилжүүлэхээр байгаа бөгөөд уг тогтоолын хүрээнд Хөгжлийн банк, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны хамтарсан ажлын хэсэг ажилласан боловч 2024 ондоо үр дүнд

хүрээгүй тул уг авлагын төлөвлөгөө биелэгдээгүй. Засгийн газар 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр 2022 оны 220 дугаар тогтоолын хэрэгжилтийг хэлэлцэж, “Монгол Улсын Хөгжлийн банкны талаар авах зарим арга хэмжээний тухай” 32 дугаар тогтоолыг баталсан. Уг тогтоолын 1.4-т “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн балансад бүртгэлтэй “Барилгын хийц үйлдвэрлэх хөдөлгөөнт цогцолбор”-ыг 25,649,932,438.09 төгрөгийн зээлийн төлбөрийн хамт Батлан хамгаалах яаманд шилжүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосон. Үүний дагуу Хөгжлийн банктай хамтран ажиллаж байна. Тоног төхөөрөмжийн гаалийн төлбөрт 2024 онд 370.0 сая төгрөг, нийт 2.4 тэрбум төгрөгийг төлөөд байна.

## **ЗЭЭЛ, ӨР ТӨЛБӨР**

Нийт өглөгийн үлдэгдлийг 27.6 тэрбум төгрөгөөр бууруулж 245.1 тэрбум төгрөгт хүргэхээр төлөвлөсөн ба гүйцэтгэлээр 273.9 тэрбум төгрөгийн өглөгтэй байгаа бөгөөд үүнээс 89 хувийг /244.6 тэрбум төгрөг/ богино хугацаат өр төлбөр, 11 хувийг /29,3 тэрбум төгрөг/ нь урт хугацаат өглөг эзэлж байна.

1. Түрээсийн орон сууцны санд шилжүүлсэн орон сууцны төлбөр 82,3 тэрбум төгрөгийг үе шаттайгаар улсын төсөвт суулгах замаар барагдуулж байгаа бөгөөд 2019-2024 онуудад 30,0 тэрбум төгрөгийг төсвөөс авч, 2024 онд гэрээний хуваарийн дагуу 1.5 тэрбум төгрөг төлөхөөр төлөвлөсөн боловч 300,0 сая төгрөгийн төлөлт хийгдэж, Дамжуулан зээлдүүлэх гэрээний үлдэгдэл дүнг ЗГ-ын 2016 оны 138, 169 дүгээр тогтоолын дагуу төсөвт буцаан төвлөрүүлэхгүй байх тул өглөгийг залруулах шаардлага үүссэн тул асуудлыг шийдвэрлэхээр аудитын байгууллагатай хамтран ажиллаж байна. Үлдэгдэл дүн: 28.2 тэрбум төгрөг.
2. Засгийн газрын 2022 оны 220 дугаар тогтоолын хүрээнд гаргасан ТОСК бондын үлдэгдэл дүн 180.5 тэрбум төгрөг. Засгийн газар 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр 2022 оны 220 дугаар тогтоолын хэрэгжилтийг хэлэлцэж, “Монгол Улсын Хөгжлийн банкны талаар авах зарим арга хэмжээний тухай” 32 дугаар тогтоолыг баталсан. Уг тогтоолын 1.1.2-т “ТОСК БОНД”-ын барьцаанд байгаа “Ногоон нуур 1008” айлын орон сууцны барилга, байгууламжийг “Нийслэлийн орон сууцны корпораци” ХК-д худалдан борлуулж, холбогдох гэрээний үнийн дүнтэй тэнцэх хэмжээгээр “ТОСК БОНД”-ын төлбөрийг 2025 онд багтаан бүрэн төлж барагдуулахыг үүрэг болгосон ба тогтоолын хүрээнд Хөгжлийн банктай хамтран ажиллаж байна.
3. Сангийн яаманд төлөх ОССК ХХК-аас ТОСК ТӨҮГ-д шилжсэн 14,6 тэрбум төгрөгийн эх үүсвэрт тооцогдсон хүү, алдангийн хэмжээ тайлант хугацаанд 23.8 тэрбум төгрөгт хүрч, Дамжуулан зээлдүүлэх гэрээний /5,0 тэрбум/ 2024 онд төсөвт буцаан төвлөрүүлсэн 300.0 сая төгрөгийг хүүгийн төлбөрийг дээрх 14,6 тэрбум төгрөгийн алдангид шилжүүлэн төлсөн. Үүрэг гүйцэтгүүлэх гэрээний хүүг зогсоох талаар Сангийн яамтай уулзалт зохион байгуулж, ажиллахаар төлөвлөж байна.
4. Барилгын гүйцэтгэлийн санхүүжилтийн үлдэгдэл, Чанарын баталгааны өглөгийн үлдэгдэл төлбөрийг барагдуулах: 2024 онд хуваарийн дагуу 470.0 сая төгрөгийг төлөхөөр төлөвлөсөн боловч санхүүгийн нөхцөл байдлаас шалтгаалан ба 415.0 сая төгрөг төлсөн. Өглөгийн үлдэгдэл 1,1 тэрбум төгрөг.

## **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛ**

Тайлант онд нийт 165.7 сая төгрөгийн хөрөнгө худалдан авахаар төлөвлөсөн ба үүнээс 6.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авалтыг улсын төсвөөс авах “Солонго1,2” төслийн техник хяналтын орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөж, өөрийн эх үүсвэрээр худалдан авалт хийгдсэн. ТОСК өөрийн хөрөнгөөр 165.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 109.3 сая төгрөгийн худалдан авалт хийж,


нийт 115.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийсэн. Худалдан авалт хийх санхүүжилтийн эх үүсвэр хүрэлцээгүйгээс шалтгаалан 56.4 сая төгрөгөөр төлөвлөгөө тасалдсан.

2024 оны батлагдсан зорилтын 3 дугаар хавсралтаар хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийн бэлтгэл ажилд зарцуулагдах зардлыг төлөвлөсөн. Тайлант онд “Солонго 1,2”, “Эко яармаг”, “Залуус”, орон нутаг дахь төслүүдийн бэлтгэл ажил болон түр суурьшуулахын зардалд санхүүжилтийн эх үүсвэрээс хамаарч 330.7 сая төгрөгийн санхүүжилт хийгдсэн. Энэхүү хөрөнгө оруулалтын зардлууд нь эх үүсвэртэй уялдан санхүүждэг.

| Д/д | Төслийн нэр                                           | Зардлын нэр                                                                                          | Хэмжих нэгж | 2024 оны батлагдсан төлөвлөгөө | 2024 оны тодотгосон төлөвлөгөө | БИЕЛЭЛТ   |
|-----|-------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------|-------------|--------------------------------|--------------------------------|-----------|
| 1   | Эко яармаг                                            | Түр суурьшлын зардал /38/                                                                            | мян.төг     | 456,000.0                      | 300,500.0                      | 300,500.0 |
| 2   |                                                       | Бэлтгэл ажлын зардал                                                                                 | мян.төг     | 335,482.0                      | 330.0                          | 330.0     |
| 3   | Солонго 1                                             | Бэлтгэл ажлын зардал                                                                                 | мян.төг     | 225,830.8                      | 8,870.4                        | 8,870.4   |
| 4   | Солонго 2                                             | Бэлтгэл ажлын зардал                                                                                 | мян.төг     | 132,064.1                      | 6,725.4                        | 6,725.4   |
| 5   | Залуус 1                                              | Бэлтгэл ажлын зардал                                                                                 | мян.төг     | 1,225,535.4                    | 8,320.4                        | 8,320.4   |
| 6   | Багануур дүүрэг, Баянзүрх дүүрэгт хэрэгжүүлэх төслүүд | Бэлтгэл ажлын зардал                                                                                 | мян.төг     | 778,743.1                      | -                              | -         |
| 7   | Орон нутаг /Ховд, Хэнтий, Архангай, Хөвсгөл/          | Бэлтгэл ажлын зардал                                                                                 | мян.төг     | 431,339.5                      | 5,978.5                        | 5,978.5   |
| 8   | Бусад ажил                                            | Хөрсний ус нэвчилт зогсоох 1021, 1022 дугаар байр, орон нутгийн дуусаагүй суурийн барилгын түр хашаа | мян.төг     | 529,022.1                      | -                              | -         |
| ДҮН |                                                       |                                                                                                      |             | 4,114,016.9                    | 330,724.7                      | 330,724.7 |

ХӨРӨНГИЙН ӨГӨӨЖИЙГ САЙЖРУУЛСАН БАЙДАЛ

2024 онд нийт хөрөнгийн хэмжээ өмнөх жилээс 13,1 тэрбум төгрөгөөр өсөж 238.1 тэрбум төгрөгт хүрсэн боловч тайлант онд алдагдал өсөж сүүлийн 5 жилийн дундаж өсөлт нь -5,5 хувь байсныг -7,3 хувьд хүргэж бууруулсан.



Эрчим хүчний хэмнэлттэй орон сууцны төслийг орон нутагт хэрэгжүүлэх санхүүжилтийн эх үүсвэр болох 13,1 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгийг улсын төсвөөс шилжүүлэн авсан нь нийт хөрөнгө өсөхөд нөлөөлсөн.

### **ТӨРИЙН ӨМЧИЙН НОГДОЛ АШГИЙН ГҮЙЦЭТГЭЛ, УЛС ОРОН НУТГИЙН ТӨСӨВТ**

2024 онд төсөвт төлбөрт нийт 3.4 тэрбум төгрөгийг төвлөрүүлэхээс 4.1 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн нь төсөвлөснөөс 18 хувиар өссөн. Тус онд компани санхүүгийн тайлангаар 17.3 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан учраас ногдол ашиг төвлөрүүлээгүй.

-----o0o-----